

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 3 ДУГААР АНГИЙН НЭГДМЭЛ АГУУЛГЫН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

3..... ангийн сурагч овогтой

ХУГАЦАА 40 МИНУТ

НИЙТ 18 ОНОО

Хувилбар А

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР
Эхийг уншаарай.

Сонгох даалгавар бүр 1 оноотой.

Ээжийн цамц

Нэгэн өдөр Сувдаа охины ээж ажил ихтэй байсан болохоор цамцаа угааж чадалгүй ажилдаа явсан байв. Тэр цамц ээжийнх нь хувцасны дотроос хамгийн гоёмсог нь байлаа. Сувдаа ээждээ туслахаар цамцыг угаав. Угаалгын машинд хийн угааж, хэцэн дээр тохлоо. Оройхон цамцаа үзтэл дүүд нь таарахаар жижиг болсон байв. Ээж удахгүй ажлаасаа ирнэ. Сувдаа охин сандран, цамцыг авч индүүдэн сунгаж татсан боловч том болсонгүй. Хаалга тогшив. Тэр ээжээсээ айгаад цамцаа нууж орхижээ.

1. Сувдаа ээжийнхээ цамцыг яагаад угаасан бэ? 1 оноо

- А. Ээж нь ажил ихтэй байсан болохоор
- Б. Ээждээ туслах гэж угаасан
- В. Хувцас угааж үзэх гэж

2. Цамц нь яагаад дүүд таарахаар жижиг болсон бэ? 1 оноо

- А. Халуун усанд угаасан.
- Б. Угаагаад мушгиж өлгөсөн.
- В. Таних тэмдгийг хараагүй угаасан.

3. Оноосон нэртэй хэсгийг олоорой. 1 оноо

- А. Сувдаа охин
- Б. Ээжийн цамц
- В. Хаалга тогших

4. $7+7=Э$ дүрэмд тохирох үгтэй хэсгийг сонгоорой. 1 оноо

- А. Өргөн, асуухад
- Б. Хулан, Өргөн
- В. Өгвөл, үйлдэл




5. 7мянга 5аравтыг агуулсан тоог олоорой. 1 оноо

- А. 75 Б. 7500 В. 7050 Г. 750

6. 6533 тоог 1000 таар тоймлоорой. 1 оноо

- А. 6000 Б. 7000 В. 6500 Г. 7500

7. Харилцан зэрэгцээ шулуун аль нь вэ?/1оноо/



8. Зурагт таван өдрийн агаарын хэмийг харуулсан байна. Хамгийн дулаан шөнийг дугуйлаарай. / 1 оноо/



А. Даваа Б. Баасан

В. Бямба Г. Ням

ХОЁР: ЗАДГАЙ ДААЛГАВАР

9. Дараах өгүүлбэр дэх тодруулсан үгийн ойролцоо ба эсрэг утгыг бичээрэй. 2 оноо

Дүүд нь таарахаар жижиг болсон байв.

Эсрэг утга..... ойролцоо утга.....

10. Дээрх эхийг уншаад бүтцийн дагуу бичээрэй. 3 оноо

Эхлээд

.....
.....

Дараа нь

.....
.....

Төгсгөлд нь

.....
.....

11. Үйлдлийг гүйцэтгээрэй. 2 оноо

А. $593\text{см} + 204\text{см} =$

Б. $294\text{см} - 89\text{см} =$

12. Хүснэгтэд өгсөн өгөгдлийг уншаад асуултад хариулаарай. 3 оноо

№	Хүүхдүүдийн нэр	Үсэрсэн тоо
1	Дорж	15
2	Сувд	22
3	Амар	10
4	Болд	15
5	Туяа	34

А. Туяа Болдоос хэдээр олон үсэрсэн бэ? _____

Б. Адил тоотой үсэрсэн хүүхэд хэн хэн байна вэ?

_____ , _____

Г. Бүх хүүхэд нийлээд хэд үсэрсэн бэ? _____

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 3 ДУГААР АНГИЙН НЭГДМЭЛ ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

3..... ангийн сурагч овогтой

ХУГАЦАА 40 МИНУТ

ХУВИЛБАР Б

НИЙТ 18 ОНОО

Сэлүүрдэх гэсэн юм

Сохор номин:

- Би сэлүүрдэж үзмээр байна, тэгэх үү?

- Цаг нь арай болоогүй байна, найз минь. Чамд сэлүүрдэх хичээл заасны дараа хийхэд оройтохгүй. Сэлүүрдэнэ гэдэг харагдаж байгаагаасаа хэцүү шүү гэж харх хэлэв. Сохор номин хархыг хараад атаархаж эхлэв. Биеэ тоосон чанар нь түүнд “Чи сэлүүрдэж чадна аа.Маш сайн” гэж шивнэх аж. Харх эргэн тойрон дахь усны мандлыг анхааралтай ажиглан сэлүүрдэнэ. Сохор номин гэнэт хархын дэргэд үсрэн очиж сэлүүрийг шүүрч авахад харх урагшаа унаж, хөл нь агаарт сарвалзав.

- Хүүе! Чи болиоч, одоо живүүлэх нь байна шүү дээ гэж харх хэллээ.

1. Яагаад “ Цаг нь болоогүй байна “ гэж хэлсэн бэ? 1 оноо

1. Сохор номиноос сэлүүрээ харамласан учраас
2. Сохор номин сэлүүрдэх хичээлд суугаагүй учраас
3. Сохор номин сэлүүрдэх хүсэлтэй болохоор

2. Эхийн үйл явдлын дарааллыг зөв байрлуулсан хэсгийг ол. 1 оноо

1. Хүүе! Чи болиоч, одоо живүүлэх нь байна шүү дээ гэж харх хэллээ.
2. Сохор номин хараад атаархаж эхлэв.
3. Цаг нь арай болоогүй байна. найз минь.

А. 1, 2, 3 Б. 2,1,3 В. 3, 2, 1 Г. 1, 3, 2

3. Оноосон нэртэй хэсгийг олоорой. 1 оноо

- А. Үсрэн харайх
- Б. Шүүрч авах
- В. Сохор Номин

4. Зөв бичсэн үгийг ол. 1 оноо

- А. мандлыг Б. мандалыг В. Мандалийг


5. 8мянга баравтыг агуулсан тоог олоорой. 1 оноо

- А. 86 Б. 8600 В. 8060 Г. 860

6. 5627 тоог зуутаар тоймлосон зөв хариуг олоорой. 1 оноо

- А. 5700 Б. 5030 В. 5600 Г. 5000

7. Аль дүрсийн тэгш хэмийн тэнхлэгийг зөв зурсан байна вэ?



A. б Б. а В. г Г. в

8. Хүснэгтийг ажиглаад хамгийн дулаан өдрийг дугуйлаарай. 1 оноо

Дорнод - Халхгол сум (Харуул: Ялалт баг)				
ЛХАГВА 2024-05-29 Шөнө 9°C 7м/с Өдөр 18°C 6м/с	ПҮРЭВ 2024-05-30 Шөнө 6°C 6м/с Өдөр 16°C 9м/с	БААСАН 2024-05-31 Шөнө 6°C 5м/с Өдөр 20°C 6м/с	БЯМБА 2024-06-01 Шөнө 6°C 4м/с Өдөр 24°C 6м/с	НЯМ 2024-06-02 Шөнө 9°C 4м/с Өдөр 26°C 6м/с

A. Даваа Б. Лхагва В. Бямба Г. Ням

ХОЁР: ЗАДГАЙ ДААЛГАВАР

9. Дараах өгүүлбэр дэх тодруулсан үгийн ойролцоо ба эсрэг утгыг бичээрэй. 2 оноо

Цаг нь болоогүй байна **найз** минь.
 Эсрэг утга..... ойролцоо утга.....

10. Дээрх эхийг уншаад бүтцийн дагуу бичээрэй. 3 оноо
 Эхлэл

.....

.....

....

Дараа нь

.....

.....

....

Төгсгөлд нь

.....

.....

11. Хугацааны нэгжүүдийг заасан нэгжээр илэрхийлээрэй. 2 оноо

A. 14 цаг +24цаг = Б. 120 өдөр – 60 өдөр =

12. Зурган диаграммыг ажиглаад асуултад хариулаарай. 3 оноо

Лууван	⬡ ⬡ ⬡ ⬡
Улаан лооль	⬡ ⬡ ⬡ ⬡ ⬡ ⬡
Цэцэгт байцай	⬡ ⬡ ⬡
Хаш	⬡ ⬡

Түлхүүр: ⬡ нь 5 кг

A. Лууван хэдэн ширхэг байна вэ? _____

Б. Улаан лооль хашаас хэдээр олон байна вэ? _____

В. Нийт ногооны тоог олоорой. _____

Түлхүүр

Хувилбар А

№	Хариулт	оноо
Монгол хэл		
1	Б	1 оноо
2	В	1 оноо
3	А	1 оноо
4	Б	1 оноо
5	В	1 оноо
6	Б	1оноо
7	А	1оноо
8	Г	1оноо
Задгай даалгавар		
9	Жижиг – том , бага	2 оноо
10	Цамцаа угааж чадалгүй ажилдаа явсан Ээждээ тусалж цамцыг угаасан. Угаасан цамц нь агшсан. Ээжээсээ айгаад цамцаа нуусан.	3оноо
11	$593\text{см}+204\text{см}=797\text{см}$ $294\text{см}-89\text{см}=205\text{см}$	2оноо
12	А. 19 үсэрсэн Б. Дорж, Болд Г. 96	3оноо

Түлхүүр

Хувилбар Б

№	Хариулт	оноо
Монгол хэл		
1	Б	1 оноо
2	В	1 оноо
3	В	1 оноо
4	А	1 оноо
5	В	1 оноо
6	В	1оноо
7	Г	1оноо
8	Г	1оноо
Задгай даалгавар		
9	Найз – нөхөр, дайсан	2 оноо
10	Сохор номин сэлүүрдэж сурахыг хүссэн. Харахыг хараад атаархаж эхэлсэн. Сохор номин хархыг сэлүүрийг шүүрч авсан.	3оноо
11	А. 38 цаг 60цаг	2оноо
12	А. 20кг Б. 20кг аар олон Г. 75кг	3оноо

